



НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Тогтвортой хөгжлийг хангах үндэс суурь бүрдсэн байна. Хүн амын бичиг үсэг тайлагдсан байдал, хүний хөгжлийн индексээр өндөр үзүүлэлттэй байгаа зэрэг нь цаашид тогтвортой хөгжлийг хангах үндэс суурь бүрдсэн болохыг илэрхийлнэ.

Тэгш бус байдал гүнзгийрч, эдийн засгийн өсөлт нэг салбараас хараат, эмзэг, тогтворгүй байгаа нь Монгол Улсад ТХЗ-ын хөгжлийн үндэс суурийг бий болгох талаар гаргаж байгаа амжилтад сөргөөр нөлөөлж байна. Монгол Улс тогтвортой хөгжлийн замналаар хөгжин дэвжихийн тулд “төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх” зарчмыг хэрэгжүүлж, олон талын оролцоог хангасан илүү оновчтой, нээлттэй хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улс хүний хөгжлийн түвшин өндөртэй улс орны ангилалд багтаж байгаа хэдий ч ажилгүйдэл, ядуурал ужигарч, тэгш бус байдал гүнзгийрч байгаа нь хөгжил дэвшилд саад тээг болж, улмаар хөгжлөөс хүн амын зарим бүлэг хоцрогдох эрсдэл байгаа нь цаашдын тулгамдсан асуудлын нэг болж байна. Иймээс “хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчимд нийцүүлэн эрхэд суурилсан хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд анхаарах шаардлага тулгарч байна.

Үүний тулд дараах асуудлуудад онцгойлон анхаарч цогцоор нь авч үзэх нь зүйтэй юм. Үүнд:

1. Бодлогын харилцан уялдаатай, нэгдмэл, залгамж чанартай, тогтвортой байдлыг хангасан, сайжруулсан бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх.

Монгол Улсын Засгийн газар нь харилцан уялдаагүй, хэрэгжих магадлал муутай хэт олон бодлогын баримт бичгүүдийг юуны түрүүнд нэн даруй цөөлж цэгцлэх


шаардлагатай тулгарч байна. Одоо байгаа үндэсний болон салбарын бодлогын сайжруулж, ТХЗ-ыг урт хугацааны бодлогодоо бүрэн тусган нутагшуулах, зорилго, зорилт, хүрэх түвшинг тодорхойлох замаар дунд хугацааны бодлогоо шинэчлэх, уялдааг нь сайжруулах, дунд болон богино хугацааны хөгжлийн нэгдсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Ингэхдээ нийгэм, эдийн засгийн болон бүс нутгийн хөгжлийг дэмжих, ялгаварлан гадуурхалтыг зогсоох, эрх тэгш боломжийг олгоход чиглэсэн цогц бодлого, хөтөлбөрийн хүрээнд орон нутагт хүн ам жигд хөгжих бололцоог бүрдүүлэхэд онцгойлон анхаарах нь чухал байна.

2. Институцын тогтолцоог боловсронгуй болгох

Институцын тогтолцоонд нөлөөлж буй нэг гол хүчин зүйл нь улс төрийн тогтворгүй байдал бөгөөд өнгөрсөн 28 жилд Засгийн газар дунджаар 1.5 жил ажилласан байна. Үүнтэй холбоотойгоор төрийн алба тогтворгүй, бодлогын залгамж алдагдах сөрөг нөлөөлөл гарч байгааг арилгах зорилгоор төрийн албаны шинэчлэлийг эхэлсэн бөгөөд амжилттай хэрэгжүүлэх нь нэн чухал хүчин зүйл мөн. Үүний тулд “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-д өөрчлөлт оруулж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг байгуулж, яамдын чиг үүргийг шинэчилж, нэгдсэн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

3. Хэрэгжилтийн механизмыг бүрдүүлэх

ТХЗ-ын хэрэгжилт үндэсний болон орон нутгийн түвшинд хангалтгүй байна. Хэрэгжилтийг хангахдаа нэгдсэн зохицуулалтаар, хариуцах чиг үүргийг нь тодорхой болгож, үр дүнгийн хяналтын механизмыг бүрдүүлж, хариуцлагын тогтолцоотой уялдуулах хэрэгтэй. Бодлогыг хэрэгжүүлэхдээ хүний нөөцийн чадавхи, бүх түвшинд мэдлэг, хандлагыг өөрчлөх, оролцоог дээшлүүлэх нь хөгжлийн бодлогын зорилтыг хангах гол хүчин зүйл болно.



4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх.

Урт хугацааны үндэсний хөгжлийн бодлого батлагдсан ч түүнийг хянах шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлсон байдал нь хангалттай бус байна. ТХЗ-ын хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох үйл явцад ахиц дэвшил гарч байгаа боловч тэдгээрийг нутагшуулж, орон нутгийн түвшинд гаргах олон ажил хүлээгдсээр байна. Үр дүнд суурилсан хяналтыг сайжруулж, тогтмолжуулах, төрийн албан хаагчийн хариуцлагын механизмтай уялдуулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

5. Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх хөгжлийн тэргүүлэх чиглэлийг хангах санхүүжилтийн стратегийг боловсруулах.

Урт хугацааны хөгжлийн зорилгыг хангахад санхүүжилтийн хэрэгцээг тооцох, төлөвлөх, төр, хувийн хэвшил, гадаад эх үүсвэрээс нэмэлт эх үүсвэрийг бүрдүүлэхэд чиглэсэн нэгдсэн стратеги зайлшгүй хэрэгцээтэй байна.

Холбоо барих:

Үндэсний хөгжлийн газар

Монгол Улс, Улаанбаатар хот 151610,

Чингэлтэй дүүрэг,

Нэгдсэн Үндэстний гудамж 5/1

Утас: (976) 51-263333

И-мэйл: info@nda.gov.mn

Вэб сайт: www.nda.gov.mn





MONGOLIA

CONCLUSIONS AND RECOMMENDATIONS

There is significant potential for sustainable development. Human development related indicators, such as high literacy rates and human development index, have created a sound foundation for ensuring future sustainable development in Mongolia. The VNR has contributed to improving multi-stakeholder dialogue and building consensus among stakeholders.

Deepening inequality, heavy dependency on one sector and the overall fragility of economic development may jeopardize the existing foundation for SDG achievement. Mongolia recognizes the criticality of “all-of-government” and “all of society” approaches in achieving sustainable development and the importance of creating a more inclusive and transparent development policy and planning system that ensures multi-stakeholder participation. While Mongolia is a country with high-medium-level human development, the increasing unemployment, poverty and inequality have become a hindrance to development and hence some of the

population’s vulnerabilities to development are becoming one of the main challenges for the country. Therefore, it is necessary to pay attention to the determination and implementation of rights-based development policies in accordance with the principles of “leave no one behind”.

In order to do this, it is important to focus on the following issues in an integrated manner:

1. Developing and Implementing Comprehensive, Coherent Policies while Ensuring their Continuity and Sustainability

The Government needs to systematize its policy documents by reviewing them for policy coherence. It is necessary to

The infographic displays the 17 Sustainable Development Goals (SDGs) for Mongolia. Each goal is represented by a colored square with an icon and Mongolian text. The goals are arranged in a grid: Row 1 (Goals 1-5), Row 2 (Goals 6-10), Row 3 (Goals 11-14), Row 4 (Goals 15-17). The bottom right corner features the 'SUSTAINABLE DEVELOPMENT GOALS' logo and the 'MONGOLIA' logo.



update the medium-to-short term policies, ensure their coherence and develop medium and short term development strategies reflecting full SDG localization and defining medium and short term targets. In doing so, the country needs to develop and implement an economic diversification policy that creates productive employment, eliminate discrimination, and provides better opportunities for people living especially in rural areas.

2. Strengthening the Institutional Framework

A major obstacle in ensuring institutional excellence is political instability associated with frequent changes in the government. Over last 28 years the average term of a government was 1.5 years, which affects the stability of the civil service and causes loss of institutional memory. The public service reform underway is an opportunity to address this challenge also.

Thus, the law on development policy planning needs to be amended, with provisions to establish a state authority in-charge of policy coherence and coordination and reform the current structures of ministries and their functions.

3. Creating Implementation Mechanisms

SDG implementation has been slow at both national and sub-national levels. The implementation needs to be accelerated by institutionalizing coordination mechanisms with defined roles and responsibilities and performance-based monitoring and evaluation systems. In the implementation of development policies, the availability of resources and capacities, public awareness, and the extent of multi-stakeholder participation, especially of the most disadvantaged sections, needs to be strengthened.

4. Establishing a Monitoring and Evaluation Framework

Even after the adoption of a longterm development policy, monitoring indicators and targets have not been defined yet for the SDGs. Work has been defining SDG national indicators and targets for Mongolia, but more efforts to localize and

define them at local levels are needed.

Enhancing and institutionalizing performance-based monitoring, and strengthening accountability mechanisms for the civil servants are other important areas.

5. Developing a Financing Strategy for Implementing Priority Measures Towards Achieving SDGs

To achieve long-term development goals, a sound financing strategy is critical. This strategy needs to include estimated cost requirements, allocations aligned with policy priorities, defined sources of funding from public and private sources, and resource mobilization strategies.

6. Ensuring Multi-Stakeholder Participation and Partnerships

It is important to strengthen SDG awareness among all actors. Inadequate awareness and knowledge of development policies, and the absence of a relevant legal environment can be impediments for policy implementation, monitoring, accountability, and transparency. Transparency of information not only helps improve monitoring, but also contributes to creating awareness among the public.

Strengthening anti-corruption and fair competition policies, transparency and public oversight are also essential. Ensuring disclosure of information to the public not only leads better monitoring, but is also vital for changing public perception and attitudes. Supporting the development of civil society organizations as agents of equitable development, promoting a rights-based approach, community mobilization, advocacy and capacity building, and reflecting these initiatives policy and legal documents are also essential ingredients for inclusion.

Contact address:

National Development Agency
United Nations Street 5/1

Ulaanbaatar 15160, Mongolia

Telephone: (976) 51-263333

Email: info@nda.gov.mn

Website: www.nda.gov.mn

